

**“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН
2022 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Улаанбаатар хот

2022 оны 04 - р сарын 27

Хурал эхэлсэн цаг: 11.10

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан
3. 2022 оны зорилт, төлөвлөгөө
4. Ногдол ашгийн тухай

Хурлын явц:

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Нарантуяа хурлын дэгийг танилцуулав.
Хурлын дэгтэй холбоотой санал хэлэх хүн байна уу?

Хурлын дэгтэй холбоотой санал өгөх хүн **Байхгүй** хурлын дэгийг батлав.

ХЗБ комиссын дарга: Тооллогын комиссын даргаар О.Оюунжаргалыг сонгох саналтай байна, Та бүхэн саналаа хэлнэ үү?

Санал нэг байгаа тул Тооллогын комиссын даргаар О.Оюунжаргалыг томилохыг 100 хувийн саналаар зөвшөөрлөө. Тогтоол №01-ийг уншиж танилцуулав.

Хурлын ирц: Хувьцаа эзэмшигчдийн хуралд ҮЦТХТ ХХК- иас 2022 оны 04 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 12,262,590 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсон нь саналын эрхтэй нийт 15,869,233 ширхэг хувьцаанаас 77,27 % болсон тул хурал хүчин төгөлдөр болсон. Тооллогын комиссын тогтоолыг №02 танилцуулав

Нийт хувьцааны тоо	15 869 233
Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо
Ц.Чингүүнболд	1824000
Ц.Оргилболд	912000
Б.Осолгүйгэрэл	30000
С.Баярцэцэг	6000
Б.Нарантуяа	50000
Б.Цогтгэрэл	3548345
“БиДиСек ҮЦК” ХК	5240005
Д.Эрдэнэчимэг	652230
С.Уранчимэг	10
Нийт ирсэн нь	12262590
Нийт хувьцаанд эзлэх хувь	77.27 %

Б.Нарантуяа: За ингээд хурлын дэгийн дагуу дараагийн асуудал хурлын даргыг сонгох ёстой, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Цогтгэрэлийг сонгох саналтай байна?

Эсрэг саналтай хүн гараагүй тул 100 хувийн саналаар Б.Цогтгэрэлийг ХЭХ-ын даргаар сонгов. Тогтоолыг №03 уншиж танилцуулав.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлын дарааллаар Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа: "Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метрийн урттай Ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил"-аас түншлэлийн хүрээнд нийт 7470 метрийг хийж гүйцэтгэн, инженер техникийн 4 ажилтан, операторчин жолооч - 4, үндсэн 5, туслах 4, нийт 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ.

Дээрх төслийн ажлыг 2017 оны үнэлгээгээр 5 дахь жилдээ сунган гүйцэтгэж байгаа нь алдагдал өсөх бодитой шалтгаан болсон. Гэрээний хугацаа сунах үндсэн шалтгаанууд нь авто зам хуулж хийх зөвшөөрөл богино хугацаатай гардаг, газар чөлөөлөлт хугацаандаа хийгддэггүй зэрэг үндсэн шалтгаануудаас хамааралтай байдаг.

Бид 2021 онд НЗДТГ-ын захиалгаар хэрэгжүүлж буй "Зүүн хойд бүсийн усан сангаас тасганы усан сан хүртэл Ф900мм-ийн цэвэр ус дамжуулах шугамын ажил"-ыг Грийн ресурс констракшн" ХХК-тай 2021.06.25-ны өдөр байгуулсан №ТС-21/029 тоот гэрээний үндсэн дээр 570 метр шугам угсралт суурилуулалтын ажлыг 2021.09.03-ны хуацаанд хийж гүйцэтгэн, хийгээр шахаж туршин хүлээлгэж өгсөн.

Санхүүгийн үйл ажиллагааны хувьд 1 216.3 сая төгрөгийн борлуулалт, 795.3 сая төгрөгийн зардал гарган 99.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Тайлант хугацааны борлуулалтын орлого нь өмнөх оныхтой харьцуулахад 93.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зардал өмнөх оныхтой харьцуулахад 14.2 сая төгрөгөөр буурсан. Тайлант жилд гарсан үйл ажиллагааны зардлыг дотор нь ангилж үзвэл 124.5 сая төгрөг цалин хөлс, 18.6 сая төгрөг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 373.1 сая төгрөг зээлийн хүүгийн зардал, 37.0 сая төгрөг засвар үйлчилгээний зардал, 3.0 сая төгрөг шуудан холбооны зардал, 3.7 сая төгрөг ашиглалтын зардал, 34.8 сая төгрөг түрээсийн зардал, 101.1 сая төгрөг элэгдлийн зардал, 2.6 сая төгрөг бичиг хэргийн зардал, 7.8 сая төгрөг хүлээн авалтын зардал, 73.5 сая төгрөг бусад зардал тус тус эзэлж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 4 099,0 сая төгрөгийн хөрөнгөтэй байгаагаас эргэлтийн хөрөнгө 3 317.5 сая төгрөг буюу нийт хөрөнгийн 80.9 %-ийг, эргэлтийн бус хөрөнгө 781.5 сая төгрөг буюу нийт хөрөнгийн 19.1 % -ийг тус тус эзэлж байна.

Тайлант жилд бид НДШ-33.7 сая, ХАОТатварт-5.0 сая, газрын төлбөрт 7.8 сая, авто тээвэрт-1.0 сая төгрөг тус тус нийтдээ 47.5 сая төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлээд байна.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Гүйцэтгэх захирлын 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонслоо. Өнгөрсөн жилийн үйл ажиллагааг гүйцэтгэлийн хувьд хангалттай гэж ТҮЗ дүгнэсэн. Учир нь хот дотор трассын асуудал хүнд, саад бэрхшээл их байгаа ч талбайн ажлын гүйцэтгэл сайн явагдсан байна. Харин энэ жил ажлаа гэрээний хугацаанд гүйцэтгэх хэрэгтэй.

Түншлэлийн компани ажлаа гүйцэтгэж дуусаагүйгээс үүдэн бид олж болох ашгаа зээлийн хүүнд төлж байгаа нь учир дутагдалтай байна. Иймд санхүүгийн үйл ажиллагааг хангалтгүй гэж дүгнэсэн.

Гүйцэтгэх захирлын тайлантай холбоотой асуух зүйл байна уу?

Ц.Оргилболд: Төслийн ажлын гэрээний хугацаа хэзээ дуусах вэ, хамтрагч компани хэдэн хувийн гүйцэтгэлтэй байгаа вэ?

Б.Нарантуяа: Энэ 2022 оны 08 дугаар сарын 30-нд гэрээний хугацаа дуусах ба төслийг дуусгаж улсын комисст хүлээлгэн өгөх ёстой.

Д.Эрдэнэчимэг: Тендерт оролцох боломжтой юу?

Б.Нарантуяа: Өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр, төлбөр ихтэй, санхүүгийн хувьд алдагдалтай гарч байгаа тул аливаа тендерт оролцох шалгуурыг хангахгүй байна. Мөн энэ жил ОХУ Украин руу дайн хийж байгаа нь шатахуун болон гадаадаас материал татан авалт,

тээвэрлэлт, валютын ханшийн огцом өсөлт зэрэг нь шууд нөлөөлж байгаа тул өнгөрсөн оны төсвөөр энэ жил ажил гүйцэтгэх ямар ч боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: За өөр асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал 2022 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулах уу?

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа 2022 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулав.

Хурлын дарга: Та бүхнээс энэ асуудалтай холбоотой асуух зүйл байна уу?

2022 оны төсөв төлөвлөгөөг батлах уу?

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ХЭХ-аас 2022 оны санхүүгийн төсвийг баталлаа.

Хурлын дарга Б.Цогтгэрэл: -Дараагийн хэлэлцэх асуудал ногдол ашгийн тухай. 2021 оны компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотойгоор ТУЗ-ийн 2022 оны 02 дүгээр сарын 08-ны өдрийн ТУ322/02 тоот тогтоолоор Ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлэсэн нь

-Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэв.

- Компанийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланг “Хангалтгүй” гэж үзэж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад анхаарал тавин ажиллахыг үүрэг болгов.

-Компанийн 2022 оны зорилт, төлөвлөгөөг батлах

-Компани 2021 онд Ногдол ашиг тараахгүй байх

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ХУРЛЫН ДАРГА

Б.ЦОГТГЭРЭЛ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

О.ОЮУНЖАРГАЛ